БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/74/НА-СТА-ТШЗ**


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: П.Амаржаргал

Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2022 он

**Агуулга**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Материаллаг байдал ........ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
3.8 Аудитын гол асуудал ........ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
4. Аудитын илрүүлэлт ........ 16
4.2 Зөвлөмж ........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.18 № 2/29

танай ____________ -ны № ____________ -т

ӨЛЗИЙТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ө.ХАШБИЛЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:\alban bichig\A4.docx

0050202260

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\alban bichig\A4.docx

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **159,250,167.82** | **180,920,035.21** |
| **33** | **АВЛАГА** | 9,950,000.00 | 4,300,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 9,950,000.00 | 4,300,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 9,950,000.00 | 4,300,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 149,300,167.82 | 176,620,035.21 |
| **351** | **Түүхий эд материал** | 99,141,922.80 | 113,055,631.80 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 98,193,462.80 | 112,741,431.80 |
| 35130 | Эм боох материал | 948,460.00 | 314,200.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 50,158,245.02 | 63,564,403.41 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,919,600.00 | 2,118,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,148,954.00 | 7,099,754.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 750,000.00 | 4,000,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,065,000.00 | 3,336,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.11 | 1,071,900.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 41,274,690.91 | 45,938,149.41 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,412,769,310.64** | **3,320,476,734.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,412,769,310.64 | 3,320,476,734.20 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,380,807,310.64 | 3,288,514,734.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,353,664,656.00 | 3,358,023,120.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -202,016,543.92 | -322,703,772.06 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 28,500,000.00 | 29,783,333.44 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -28,142,857.18 | -28,856,481.50 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 162,406,725.73 | 189,687,250.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -100,171,818.45 | -101,399,527.69 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 232,586,587.89 | 249,369,570.82 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -92,984,669.43 | -112,353,989.21 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 26,965,230.00 | 26,965,230.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 31,962,000.00 | 31,962,000.00 |
| 39301 | Программ хангамж | 300,000.00 | 300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -300,000.00 | -300,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 31,962,000.00 | 31,962,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,572,019,478.46** | **3,501,396,769.41** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,572,019,478.46** | **3,501,396,769.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,572,019,478.46 | 3,501,396,769.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 821,578,958.90 | 821,578,958.90 |
| 51101 | Өмч: - төрийн | 821,578,958.90 | 821,578,958.90 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -113,000,284.56 | 1,816,377,006.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -113,000,284.56 | -113,000,284.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,929,377,290.95 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 863,440,804.12 | 863,440,804.12 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,572,019,478.46** | **3,501,396,769.41** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,211,873,438.43** | **3,178,347,348.87** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **109,848,388.43** | **2,032,461,255.87** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 109,848,388.43 | 2,032,461,255.87 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 415,500.00 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 109,432,888.43 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 00.00 | 2,019,371,172.37 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 00.00 | 13,090,083.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,094,789,200.00** | **1,108,848,523.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **874,478,300.00** | **892,898,100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 874,478,300.00 | 892,898,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **7,235,850.00** | **37,037,570.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,156,150.00 | 37,037,570.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,079,700.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **220,310,900.00** | **215,950,423.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 220,310,900.00 | 215,950,423.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,212,988,802.26** | **1,248,970,057.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,212,988,802.26** | **1,248,970,057.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,151,829,945.43** | **1,175,080,428.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **638,288,769.00** | **640,554,125.00** |
| 210101 | Үндсэн цалин | 638,288,769.00 | 440,884,079.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 151,572,320.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 48,097,726.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **80,412,714.50** | **83,918,138.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 55,108,600.00 | 60,418,738.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,342,490.00 | 5,942,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,001,145.50 | 4,753,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,080,079.00 | 1,167,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,880,400.00 | 11,636,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **204,781,318.67** | **211,700,423.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,281,211.67 | 5,734,508.00 |
| 210302 | Түлш, халаалт | 197,346,907.00 | 205,284,915.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 153,200.00 | 681,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **20,350,475.67** | **21,486,326.50** |
| 210401 | Бичиг хэрэг | 966,700.00 | 787,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,324,253.00 | 3,291,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 342,428.00 | 244,920.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 543,200.00 | 480,850.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,214,900.00 | 3,062,450.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,958,994.67 | 8,183,756.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 5,435,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **42,958,100.00** | **40,599,345.11** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,667,740.00 | 1,223,060.00 |
| 210502 | Хоол, хүнс | 40,746,960.00 | 38,824,085.11 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 543,400.00 | 552,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,827,900.00** | **4,931,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 265,500.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,562,400.00 | 4,931,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,429,500.00** | **400,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,429,500.00 | 400,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,777,350.00** | **1,888,222.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,327,350.00 | 1,234,222.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 500,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 154,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **153,003,817.59** | **169,602,348.81** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,322,600.00 | 5,349,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,354,500.00 | 3,586,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 143,326,717.59 | 160,666,948.81 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,158,856.83** | **73,889,629.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **14,558,400.00** | **51,557,348.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,046,400.00 | 18,604,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 9,566,298.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 22,866,550.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,512,000.00 | 520,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **9,126,881.33** | **00.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,126,881.33 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **37,473,575.50** | **22,332,281.50** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,473,575.50 | 22,332,281.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-1,115,363.83** | **1,929,377,290.95** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-1,115,363.83** | **1,929,377,290.95** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,102,440,550.00** | **1,145,886,093.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **415,500.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 415,500.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 415,500.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 415,500.00 | 00.00 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,102,025,050.00** | **1,145,886,093.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 874,478,300.00 | 892,898,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,235,850.00 | 37,037,570.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,156,150.00 | 37,037,570.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,079,700.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 220,310,900.00 | 215,950,423.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 220,310,900.00 | 215,950,423.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,091,477,850.00** | **1,106,832,893.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,091,477,850.00** | **1,106,832,893.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,030,318,993.17** | **1,028,643,263.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 638,288,769.00 | 640,554,125.00 |
| 210101 | Үндсэн цалин | 467,284,369.00 | 440,884,079.00 |
| 210102 | Нэмэгдэл | 107,632,100.00 | 151,572,320.00 |
| 210104 | Урамшуулал | 63,372,300.00 | 48,097,726.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 80,412,714.50 | 83,918,138.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 55,108,600.00 | 60,418,738.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,342,490.00 | 5,942,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,001,145.50 | 4,753,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,080,079.00 | 1,167,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,880,400.00 | 11,636,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 211,026,518.67 | 214,950,423.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,281,211.67 | 5,734,508.00 |
| 210302 | Түлш, халаалт | 203,592,107.00 | 208,534,915.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 153,200.00 | 681,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,655,681.00 | 12,357,970.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,004,000.00 | 1,003,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,324,253.00 | 3,291,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 342,428.00 | 244,920.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,796,900.00 | 690,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 543,200.00 | 1,117,150.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,644,900.00 | 6,009,750.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 45,941,560.00 | 52,969,485.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,616,200.00 | 588,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 40,746,960.00 | 39,895,985.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,578,400.00 | 12,484,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,477,500.00 | 6,879,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,549,600.00 | 677,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,927,900.00 | 6,202,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,429,500.00 | 400,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,429,500.00 | 400,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,777,350.00 | 1,888,222.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,327,350.00 | 1,234,222.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 500,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 154,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,309,400.00 | 14,725,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,065,900.00 | 11,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,243,500.00 | 3,725,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,158,856.83** | **78,189,629.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,558,400.00 | 51,557,348.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,046,400.00 | 18,604,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 9,566,298.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 22,866,550.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,512,000.00 | 520,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,126,881.33 | 4,300,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,126,881.33 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 37,473,575.50 | 22,332,281.50 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,473,575.50 | 22,332,281.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,962,700.00** | **39,053,200.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,962,700.00** | **39,053,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,962,700.00** | **39,053,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,962,700.00 | 39,053,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,962,700.00 | 39,053,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-10,962,700.00** | **-39,053,200.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **821,578,958.90** | **863,440,804.12** | **-113,000,284.56** | 1,572,019,478.46 |
| D01 | **2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **821,578,958.90** | **863,440,804.12** | **-113,000,284.56** | 1,572,019,478.46 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **821,578,958.90** | **863,440,804.12** | **-113,000,284.56** | 1,572,019,478.46 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,929,377,290.95 | 1,929,377,290.95 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **821,578,958.90** | **863,440,804.12** | **1,816,377,006.39** | 3,501,396,769.41 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангила л | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,110,777,700.00 | 1,086,516,241.50 | 24,261,458.5 | 97.82 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,110,777,700.00 | 1,086,516,241.50 | 24,261,458.5 | 97.82 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,086,019,000.00 | 1,067,391,741.50 | 18,627,258.5 | 98.28 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 644,343,200.00 | 640,554,125.00 | 3,789,075.0 | 99.41 |
| 210101 | Үндсэн цалин | 441,552,100.00 | 440,884,079.00 | 668,021.0 | 99.85 |
| 210102 | Нэмэгдэл | 151,642,500.00 | 151,572,320.00 | 70,180.0 | 99.95 |
| 210104 | Урамшуулал | 51,148,600.00 | 48,097,726.00 | 3,050,874.0 | 94.04 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 85,926,400.00 | 83,918,138.00 | 2,008,262.0 | 97.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,158,500.00 | 60,418,738.00 | 1,739,762.0 | 97.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,942,000.00 | 5,942,000.00 | 0.0 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,753,500.00 | 4,753,500.00 | 0.0 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,188,500.00 | 1,167,100.00 | 21,400.0 | 98.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,883,900.00 | 11,636,800.00 | 247,100.0 | 97.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 216,879,600.00 | 214,950,423.00 | 1,929,177.0 | 99.11 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,825,400.00 | 5,734,508.00 | 90,892.0 | 98.44 |
| 210302 | Түлш, халаалт | 210,372,700.00 | 208,534,915.00 | 1,837,785.0 | 99.13 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 681,500.00 | 681,000.00 | 500.0 | 99.93 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,658,100.00 | 12,357,970.50 | 300,129.5 | 97.63 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,005,600.00 | 1,003,600.00 | 2,000.0 | 99.80 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,300,000.00 | 3,291,750.00 | 8,250.0 | 99.75 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 527,700.00 | 244,920.50 | 282,779.5 | 46.41 |
| 210404 | Ном, хэвлэл | 693,500.00 | 690,800.00 | 2,700.0 | 99.61 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,120,000.00 | 1,117,150.00 | 2,850.0 | 99.75 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,011,300.00 | 6,009,750.00 | 1,550.0 | 99.97 |
| **2105** | **Нормативт зардал** | 63,346,200.00 | 52,969,485.00 | 10,376,715.0 | 83.62 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 588,800.00 | 588,800.00 | 0.0 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 50,263,200.00 | 39,895,985.00 | 10,367,215.0 | 79.37 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,494,200.00 | 12,484,700.00 | 9,500.0 | 99.92 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 46,002,800.00 | 45,933,100.00 | 69,700.0 | 99.85 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,000,000.00 | 29,930,600.00 | 69,400.0 | 99.77 |
| 210604 | Урсгал засвар | 16,002,800.00 | 16,002,500.00 | 300.0 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 405,500.00 | 400,000.00 | 5,500.0 | 98.64 |
| 210702 | Дотоод албан томилолт | 405,500.00 | 400,000.00 | 5,500.0 | 98.64 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,732,100.00 | 1,583,500.00 | 148,600.0 | 91.42 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 992,100.00 | 929,500.00 | 62,600.0 | 93.69 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | 0.0 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 154,000.00 | 86,000.0 | 64.17 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14725100.00 | 14725000.00 | 100.0 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,000,000.00 | 11,000,000.00 | 0.0 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,725,100.00 | 3,725,000.00 | 100.0 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 24758700.00 | 19124500.00 | 5,634,200.0 | 77.24 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,758,700.00 | 19,124,500.00 | 5,634,200.0 | 77.24 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,235,100.00 | 18,604,500.00 | 5,630,600.0 | 76.77 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 523,600.00 | 520,000.00 | 3,600.0 | 99.31 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,110,777,700.00 | 1,086,516,241.50 | 24,261,458.5 | 97.82 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 892,898,100.00 | 870,565,818.50 | 22,332,281.5 | 97.50 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 892,898,100.00 | 870,565,818.50 | 22,332,281.5 | 97.50 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 217,879,600.00 | 215,950,423.00 | 1,929,177.0 | 99.11 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 217,879,600.00 | 215,950,423.00 | 1,929,177.0 | 99.11 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 52.00 | 52.00 | 0.0 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.0 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 28.00 | 28.00 | 0.0 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 23.00 | 23.00 | 0.0 | 100.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 508.00 | 508.00 | 0.0 | 100.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 508.00 | 508.00 | 0.0 | 100.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 508.00 | 508.00 | 0.0 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **7,235,850.00** | **37,037,570.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,235,850.00** | **37,037,570.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 7,235,850.00 | 37,037,570.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,235,850.00 | 304,722.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,235,850.00 | 304,722.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,235,850.00 | 32,432,848.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,235,850.00 | 32,432,848.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 9,566,298.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 22,866,550.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.00** | **4,300,000.00** |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 7,235,850.00 | 37,037,570.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,235,850.00 | 37,037,570.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,235,850.00 | 37,037,570.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цэзням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд сургуулийн захирал Ө.Хашбилэг нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Б.Мөнхтогтох нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тус сургууль нь "Багш бүр хүүхдийн өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжиж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, сурах үйлийн таатай орчныг бүрдүүлэн агуулгын хоцрогдлыг арилгаж, хичээлийн цахим санг бий болгоно" . Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/37 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөх байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Өлзийт сумын

ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,211,988.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,119.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,483.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 8,742.8 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлзийт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 3,501,396.7 мянган төгрөг болж өмнөх оноос 1,929,377.3 мянган төгрөгөөр буюу 55.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 159,250.10 | 180,920.00 | 21,669.90 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | 0.00 |
| Авлага | 9,950.00 | 4,300.00 | -5,650.00 |
| Урьдчилгаа | - | - | 0.00 |
| Бараа материал | 149,300.10 | 176,620.00 | 27,319.90 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,412,769.30 | 3,320,476.70 | 1,907,707.40 |
| Үндсэн хөрөнгө | 1,836,385.10 | 3,886,090.50 | 2,049,705.40 |
| Хуримтлагдсан элэгдэл | -423,615.80 | -565,613.70 | -141,997.90 |
| **Нийт хөрөнгө** | **1,572,019.40** | **3,501,396.70** | 1,929,377.30 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,572,019.40 | 3,501,396.70 | 1,929,377.30 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,572,019.40** | **3,501,396.70** | **1,929,377.30** |

Бараа материалын дансны үлдэгдэл 176,620.0 мянган төгрөг болж 27,319.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал дансны үлдэгдэл өмнөх оноос 24,435.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба Дээд шатны төсөв захирагчаас шилжүүлж ирсэн 6,457.0 мянган төгрөгийн биеийн тамирын хичээлийн хэрэгсэл, сурах бичгүүдийг хүлээн авсан зэрэг өмнөх оноос өссөн нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,886,090.5 мянган төгрөг болж 2,049,705.4 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны төсөв захирагчаас шилжиж ирсэн 34,762.8 тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 9,800.0 мянган төгрөгийн вакум хаалга, 29,253.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу холбогдох дансанд орлогоор бүртгэсэн мөн УТХО-аар баригдсан сургуулийн барилгыг 1,994,558.4 мянга, өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн 9,950.0 мянган төгрөгийн ухаалаг самбарыг тус тус холбогдох дансанд орлогоор бүртгэж 18,669.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Тайлант онд 4,300.0 мянган төгрөгийн авлага үүссэн нь тус сургуулийн бага ангийн багш нарын бичсэн Сайн-Оюут нэртэй сургалтын цахим орчин сайжруулах төсөл нь сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн уралдаанд шалгарч БСУГ-аас олгосон санхүүжилтийг цаг үеийн байдалтай холбоотойгоор зарцуулаагүй байсан ба тус хөтөлбөрийн зардлыг санхүүжилтийн авлага үүсгэж бүртгэл тайланд тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,501,396.7 мянган төгрөг болж 1,929,377.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1,929,377.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,682,175.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,682,175.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 598,822.9 мянган төгрөгөөр бууруулж 1,083,352.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 1,110,777.7 мянган төрөг болж 27,425.6 мянган төгрөг буюу 2.4 хувиар өсөж батлагдсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,110,777.7 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 892,898.1 мянга, орон нутгийн төсвөөс 217,879.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 892,898.1 мянга, орон нутгийн төсвөөс 215,950.4 мянга нийт 1,086,516.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,086,516.2 мянган төгрөгийг зарцуулж 22,332.2 мянган төгрөг буюу 2.0 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Харин орон нутгийн төсвийн санхүүжилтийг 1,929.1 сая төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу санхүүжүүлсэн байгаа нь төсвийг гүйцэтгэлтэй нь уялдуулан олгосонтой холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,086,516.2 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай тогтмол зардлыг 1,929.1 мянга, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 3,789.0 мянга, НДШ-ын зардлыг 2,008.2 мянга, хүүхдийн хоолны зардал 10,367.2 мянга, үдийн цайны зардал 5,630.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 10003145401 тоот дансанд БСУГ-аас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 22,866.5 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 8,996.7 мянга, Тэтгэлэгт хөтөлбөрийн уралдааны шагналын мөнгө 4,300.0 мянга, шалгалтын бичиг хэргийн зардалд 298.7 мянга, хүчингүй болсон албан бичгийн тоотны үнэ 0.6 мянга нийт 37,037.5 мянган төгрөгийг олгосныг зориулалтын дагуу зарцуулан тэтгэлэгт хөтөлбөрийн уралдааны шагналын мөнгөн тэтгэмжийг цаг үеийн байдалтай холбоотойгоор зарцуулаагүй төвлөрүүлж санхүүжилтийн авлагаар бүртгэл тооцоонд тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 20 зорилт 141 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 90%-тай гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,248,970.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 88,059.0 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь хангамжийн материал өмнөх оноос буурсан бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 91 | 5 | 0 |
| | Нийт | 27 | 151 | 144 | 5 | 2 |

Тус байгууллага нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн системд нийт 1,110,777.0 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулахаас Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ өссөн дүнгээр 304,108.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл зэрэг 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Урсгал төсвийн зарцуулалт нь гүйцэтгэлээр улсын төсвөөс 870,565.8 мянга, орон нутгийн төсвөөс 215,950.4 мянга нийт 1,086,516.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,086,516.0 мянган төгрөгийг зарцуулж 22,332.2 мянган төгрөг буюу 2.0 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Мөн орон нутгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилт 216,879.6 мянган төгрөг батлагдаж 214,950.4 мянган төгрөгийн олгож төлөвлөгөөнөөс 1,929.1 мянган төгрөг буюу 0.9 хувийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Тайлант онд тогтмол зардалд 216,879.6 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 43,375.9 мянган төгрөг байна. Тус онд 1,929.1 төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 43,356.6 мянган төгрөгийн хэмнэлтийг үүсгээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалттай ~~бүрэн~~ нийцэхгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 15,138.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж хэрэгжилтийн тайланг 2021оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах аяны хүрээнд шалгасан байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа илэрч зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүллээ.

**4.2 Зөвлөмж**

4.2.1 Тайлант онд тогтмол зардалд 216,879.6 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 43,375.9 мянган төгрөг байна. Тус онд 1,929.1 төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 43,356.6 мянган төгрөгийн хэмнэлтийг үүсгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалтыг зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн:** Цаашид дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөн хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллах.

4.2.2 Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр оруулахаас Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ өссөн дүнгээр 304,108.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл зэрэг 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.4, 6.4.5 дахь хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх, удирдлагаас түүнд тавих хяналтыг сайжруулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Өлзийт сумын ЕБС | 2 | 43,356.6 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 43,356.6 |

______oOo______